



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

ДУНД ХУГАЦААНЫ СТРАТЕГИ, 2022-2025

ХХЗХ нь өмчийн бүх төрлийн аж ахуйн нэгж, иргэн харилцаа холбооны зах зээлд үр ашигтай, шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх, хуульд заасан тусгай зөвшөөрөл олгох, мэргэжлийн дүгнэлт, шийдвэр гаргах чиг үүрэг бүхий салбарын бие даасан зохицуулах байгууллага юм.

Энэхүү дунд хугацааны стратеги нь Харилцаа холбооны зохицуулах хорооны төлөвлөлтийн суурь баримт бичиг бөгөөд тус хорооны хуулиар олгогдсон бүрэн эрх, олон улсын зохицуулалтын суурь зарчимд нийцнэ.

ГАРЧИГ

УДИРТГАЛ	2
ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	4
1. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ	5
1.1 ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ХАРИЛЦАГЧИЙН СЭТГЭЛ ХАНАМЖ	5
1.2 ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН, САЛБАРЫН БОДЛОГО.....	10
1.3 ТЕХНОЛОГИ, ИННОВАЦИ	13
2 АЛСЫН ХАРАА, ЭРХЭМ ЗОРИЛГО, СТРАТЕГИ ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД	2
3. НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН ГОЛ АСУУДЛУУД	10
3.1 ЗОХИЦУУЛАЛТЫН ШИЙДВЭР ГАРГАХ, болон бусад ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	10
3.2 ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГА, НЭН ШААРДЛАГАТАЙ ЧАДВАРУУД	10
3.3 САНХҮҮЖИЛТ, САНХҮҮГИЙН УДИРДЛАГА.....	12
3.4 ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА, ДОТООД ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО.....	12
3.5 ОРОЛЦОГЧ ТАЛУУДАЙ ХАМТЫН АЖИЛЛАГАА.....	13

УДИРТГАЛ

Дэлхий нийтээр цар тахалтай тэмцсэн 2 жил хүн төрөлхтөнд холбоотой, харилцаатай байх нь ямар чухал болохыг ойлгуулсан, бидний хэрэглээний дадалд огцом өөрчлөлт орсон буюу маш олон хэрэглээ цахим хэлбэрт шилжсэнээрээ найдвартай, чанартай харилцаа холбооны сүлжээ, үйлчилгээ нь улам бүр өдөр тутмын амьдралаас салшгүй болсон, манай салбарын хувьд энэхүү гэнэтийн хэрэгцээ, шаардлагыг хангах шинэ сорилт тулгарсан он жилүүд байлаа.

Монгол Улсын Засгийн Газраас харилцаа холбоо, мэдээллийн технологийг эдийн засгийн тэргүүлэгч салбарын нэгээр зарлаж, “Цахим Үндэстэн” болох уриалгыг дэвшүүлж, харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарт институцийн томоохон өөрчлөлтийг хийж, Цахим хөгжил, харилцаа холбооны яамыг байгуулсан. Харилцаа холбооны тухай (2019), Радио давтамжийн тухай (2019), Шуудангийн тухай (2019) хуулиудад нэмэлт өөрчлөлт орж, Өргөн нэвтрүүлгийн тухай хууль (2020) шинээр батлагдаж, Цахим хөгжлийн багц хуулиуд (Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хууль; 2021) шинээр болон шинэчлэгдэн батлагдсанаар салбарын хууль эрхзүйн орчинд нэлээд өөрчлөлт орсон. Харилцаа холбооны салбар бодлогын манлайлаар шат ахих боломж бүрдсэн, хууль эрхзүйн орчин шинэчлэгдсэн энэ чухал цаг дор Харилцаа холбооны зохицуулах хороо нь алсын хараа болон зорилгоо шинэчлэн, үйл ажиллагаа, гүйцэтгэлийн хэмжүүрээ сайжруулж, ирээдүйд бидэнд зайлшгүй хэрэгтэй чадавхийг орчны шинжилгээ¹нд үндэслэн шинэчлэн тодорхойллоо. Түүнчлэн энэхүү төлөвлөлтийг шинэчлэн баталснаар хууль эрх зүйн хэрэгжилтийг зөв, зохистой аргаар түргэн шуурхай хангуулахтай холбоотой үйл ажиллагааг зохион байгуулах, зохицуулалтын үйл ажиллагаанд шаардлагатай гол нөөцийг үр ашигтай удирдах, төлөвлөлтийг оновчтой болгох, гүйцэтгэлийн үнэлгээний системийг сайжруулах зэрэг Зохицуулах хорооны дотоод хэрэгцээ, шаардлагыг хангана.

НҮБ-аас Харилцаа холбоо, мэдээллийн технологийг Тогтвортой хөгжлийг эрчимжүүлэгч² гэж тодорхойлсон бөгөөд тус хороо нь хуулиар хүлээсэн чиг үүрэг, бүрэн эрхийн хүрээнд интернетийн хүртээмж, тухайлбал суурин өргөн зурвас³-ын үйлчилгээг сайжруулах⁴, хүн ам оршин суух боломжтой газар нутаг дахь үүрэн холбоо⁵-ны хамрах хүрээг нэмэгдүүлэх, хөдөлгөөнт сүлжээний дараа үеийн технологийг нэвтрүүлэх замаар тоон хуваагдлыг арилгахад зохицуулалтын үйл ажиллагаагаар дэмжлэг үзүүлэх замаар тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд хамтран оролцох болно. Үүний хүрээнд тус хороо нь ХХМТГ⁶ -аас 2020 онд баталсан дараа (5G, 5-р) үеийн хөдөлгөөнт холбооны системийг нэвтрүүлэхэд баримтлах бодлогын чиглэлийн дагуу 2023 оноос үүрэн холбооны 5G үйлчилгээг нэвтрүүлэхтэй холбоотой зөвшөөрлүүдийг олгох бөгөөд сүлжээнд нэвтрэх нөхцөл, дэд бүтцийг хамтран ашиглах зохицуулалтуудыг хэрэгжүүлэх замаар үр ашигтай өрсөлдөөнийг бий болгож, шуурхай бөгөөд үр ашигтай байхуйц хөрөнгө оруулалтаар хэрэглэгчийг бүх төрлийн дижитал үйлчилгээг найдвартай, өндөр чанартайгаар хүлээн авах нөхцөл, боломжийг бүрдүүлэхийг зорино.

¹ Хавсралт 1

² Катализатор

³ [Indicator 17.6.1: Fixed Internet broadband subscriptions per 100 inhabitants, by speed](#)

⁴ [Indicator 17.8.1: Proportion of individuals using the Internet](#)

⁵ [Indicator 9.c.1: Proportion of population covered by a mobile network, by technology](#)

⁶ Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар, одоогийн Цахим хөгжил, харилцаа холбооны яам

Энэхүү баримт бичгийн хүрээнд тавьж байгаа бас нэг томоохон зорилт нь зохицуулалтын шаардлага тогтоох, түүний хэрэгжилтийг хангуулах үйл ажиллагааны баримтад суурилсан байдлыг нэмэгдүүлэх, үүний тулд байгууллагын өгөгдлийн чадавхийг сайжруулах, мэдээллийн урсгалыг оновчтой, тасралтгүй зохион байгуулах төслүүдийг хэрэгжүүлнэ.

Стратегийн хэрэгжилтийг үндэс нь Байгууллагын чадавхи, ялангуяа манай ажилтнуудын туршлага, ур чадвар, хичээл зүтгэл бөгөөд энэхүү төлөвлөгөөнд тодорхойлсон байгууллага болон ажилтнуудад нэн шаардлагатай чадавхийг хөгжүүлэхэд онцгой анхаарч, тогтоосон зарчим, соёл, үнэт зүйлээ баримтлах болно.

Баримт бичгийг илүү бодитой, хэрэгжихүйц байлгахын тулд үйлчилгээ эрхлэгч нарынхаа саналыг авч ажиллалаа. Бидэнд саналаа ирүүлж, хамтран ажилласан Мэдээлэл холбооны сүлжээ ХХК, РТСГ УҮГ, Мобиком корпораци ХХК, Скайнетворкс ХХК, Нэшнл Ньюс Корпорэйшн ХХК, Эс Пи Эс Эйч Ди ХХК, Ай-Эн Мобайл ХХК болон нийт үйлчилгээ эрхлэгчиддээ талархал илэрхийлье. Та бүхний санал хүсэлт нь бидний ажилд нэн чухал бөгөөд үйлчилгээ эрхлэгч, зах зээлгүйгээр аль ч зорилт хэрэгжих боломжгүй юм.


Бид хуулиар тогтоосон чиг үүргийн хүрээнд тодорхойлсон энэхүү стратегиэ хэрэгжүүлэхийн тулд жил бүр системтэйгээр төлөвлөж, оролцогч талуудын харилцаа, хүний болон бусад шаардлагатай нөөцийг стратеги суурьтай удирдаж, жил бүрийн гүйцэтгэлийг бодитой тайлагнаж ажиллах бөгөөд зорилтууд хангагдахын хэрээр зах зээл маань өсөн тэлж, Харилцаа холбоо мэдээллийн технологи нь Монгол Улсын эдийн засгийн тулгуур болно гэдэгт итгэлтэй байна.

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРОО

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

ХХЗХ нь Харилцаа холбооны сүлжээ, үйлчилгээг либералчлах, зарим хатуу зохицуулалтаас татгалзах төрийн бодлогын хүрээнд зах зээлд шударга өрсөлдөх нөхцөл бүрдүүлэх зорилгоор 1997/2002 онд Харилцаа холбооны тухай хуулиар байгуулагдсанаас хойш олон улсын зохицуулалтын сайн туршлагыг Монгол улсын холбогдох хууль, тогтоомж, зах зээл болон орчны бусад нөхцөл байдалд нийцүүлэн хэрэгжүүлэх замаар үйл ажиллагаагаа явуулж ирсэн салбарын бие даасан зохицуулах байгууллага бөгөөд үйл ажиллагааны стратеги буюу зохицуулалтын тэргүүлэх чиглэл, нөөцийн удирдлагын төлөвлөлтийг дунд хугацаа⁷гаар төлөвлөн хэрэгжүүлдэг.

Баримт бичиг нь дараах бүтэцтэй.



⁷ 3-5 жил

1. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

Зах зээлийн нөхцөл байдал, харилцагчийн сэтгэл ханамж, хууль эрхзүй бодлогын орчин, технологийн хурдацтай өөрчлөлт үйл ажиллагааг тодорхойлох гол орчин байсаар ирсэн бөгөөд үйл ажиллагаагаа илүү мэргэжлийн, технологийн болон бодлогын хөгжилд нийцсэн, үр ашигтай байлгаж, хуулиар хүлээсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэхэд эдгээр орчны өөрчлөлт, нөлөөллийг зөв, хурдтай мэдэрч, оновчтой зохицуулалтыг үр ашигтай хэрэгжүүлэх нь нэн чухал юм.


1.1 ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ХАРИЛЦАГЧИЙН СЭТГЭЛ ХАНАМЖ

ЗАХ ЗЭЭЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Харилцаа холбооны зах зээл нь интернэт, яриа, олон суваг, шуудан, үндсэн сүлжээ, өргөн нэвтрүүлэг зэрэг томоохон зах зээлүүдэд хуваагддаг бөгөөд сүүлийн жилүүдэд мэдээлэл харилцаа холбооны салбарт гарч буй хэрэглээний хандлага, цахим шилжилтийн үр нөлөөгөөр тухайн салбарын зах зээл интернэт болон түүнээс хамааралтай зах зээл, үйлчилгээний нөлөөнд өртөж эхлээд байна.

Монгол улсын хэмжээнд харилцаа холбооны салбарын зах зээлийн борлуулалтын орлогын хэмжээ 2020 онд 1.4 их наяд, 2021 онд 1.6 их наяд төгрөг болж өссөн.

2022 оны эхний хагас жилийн байдлаар 2021 оны хагас жилээс 150.4 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 909.7 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд 2022 оны эцэст хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр 1.8 их наяд хүрэх төлөвтэй байна. Зах зээлийн өсөлт нь голчлон компаниудын үйл ажиллагааны шинэчлэл, COVID-19-ийн нөлөөллөөс сэргэж байгаатай, нийгэм эдийн засгийн үндсэн үзүүлэлт болон хэрэглээний өсөлттэй хамааралтай гэж үзэж байна.




2021 оны 12 сарын 31-ний байдлаар Харилцаа холбооны зах зээлд үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл 769, радио давтамжийн тусгай зөвшөөрөл 187, радио давтамжийн эрхийн бичиг 524 -ийг олгоод байна.

Хүснэгт 2. Харилцаа холбооны салбарт үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тоо


№	Үйлчилгээний төрөл	Тоо
Харилцаа холбооны сүлжээ байгуулах, эзэмших, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх		23
1.1	Мэдээлэл холбооны үндсэн сүлжээ, дэд бүтэц байгуулах, эзэмших, ашиглах (Улс хооронд/Транзит)	4
	Мэдээлэл холбооны түгээх сүлжээ, дэд бүтэц байгуулах, эзэмших, ашигла	1
	Мэдээлэл холбооны үндсэн сүлжээ, дэд бүтэц байгуулах, эзэмших, ашиглах (Хот, хот хооронд)	6
1.2	Сансрын холбооны сүлжээ байгуулах, эзэмших, ашиглах ангиллын зөвшөөрөл эзэмшигчид	4
1.3	Шуудангийн сүлжээ	
	- Улс хоорондын	2
	- Хотын доторхи	2
	-Хот хооронд	4
Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх		
2.1	Улс хоорондын ярианы үйлчилгээ	6
2.2	Хот, хот хоорондын ярианы үйлчилгээ	
	- Үүрэн	5
	- Суурин	8
	Сансрын хөдөлгөөнт холбоо	2
	Интернэтийн үйлчилгээ	67
Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ		
3.1	Радио, телевизийн газрын сүлжээ	2
3.2	Өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ	84
3.3	Өргөн нэвтрүүлгийн радиогийн үйлчилгээ	60
3.4	Арилжааны телевизийн үйлчилгээ	59
3.5	Төлбөртэй телевизийн үйлчилгээ	11
Олон суваг дамжуулах үйлчилгээ		
3.6	Кабелийн телевиз	29
3.7	АйПиТВ /IPTV/	2
3.8	Хиймэл дагуулын телевиз	2
3.9	Интернэтэд протоколд суурилсан үйлчилгээ /OTT/	1
Шуудангийн үйлчилгээ		
4.1	Үндсэн	6
4.2	Буухиа	8
4.3	Логистик	7
4.4	Улс хоорондын шуудангийн илгээлт	64
4.5	Шуудангийн захиалгат болон нэмэлт үйлчилгээ	52
Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт засвар үйлчилгээ		269
Контентийн үйлчилгээ эрхлэх		2
1	Контент нийлүүлэх үйлчилгээ	2
НИЙТ		769

Дэлхий даяар хөдөлгөөнт болон суурин өргөн зурвасын нэвтрэлт, хэрэглээ өдөр, цаг минутаар өсөн нэмэгдэж, хэрэглэгчийн хэрэглээ, бизнес моделууд ч түүнийг даган хувьсан өөрчлөгдөж байна. Харилцаа холбооны салбарт үйлчилгээнүүд нь зарим тохиолдолд нэгнийгээ шууд болон шууд бусаар харилцан орлох, хэрэглээ, хэрэгцээг өөр технологиор орлуулах боломжтой болсоор байгаа нь зах зээлийн бүтэц, харилцан хамаарал, түүний дотор эзлэх хувь, хэмжээг өөрчлөх хандлагатай байна.

Зураг . Харилцаа холбооны салбарын үйл ажиллагааны бүтэц



Зураг . Тусгай зөвшөөрөлтэй эрхэлдэг үйлчилгээнүүдийн орлогын бүтэц (100% дотор)



Интернэт, интернэтэд суурилсан үйлчилгээ, хэрэглэгчийн сонголтод нөлөөлөх (VAS) нэмэлт үйлчилгээнүүд харилцаа холбооны салбарт шинээр нэмэгдэж байна.

Зохицуулалтын орчин нөхцөл болон тусгай зөвшөөрлийн хэлбэр агуулгаас гадна зах зээл, хэрэглэгчийн сонголтод суурилсан хувьсан өөрчлөгдөж байгаа хэрэгцээ шаардлагад нийцэхүйц уян хатан зохицуулалтын орчин илүү чухал байна.


ХАРИЛЦАГЧИЙН СЭТГЭЛ ХАНАМЖ

Тус хороо нь 2022 оны 6-р сард Харилцаа холбооны тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс зохицуулалтын үйл ажиллагааны талаар сэтгэл ханамжийг мэргэжлийн байгууллага⁸ар гүйцэтгүүлсэн бөгөөд судалгааны хүрээнд зохицуулалтын үйл ажиллагааны өнөөгийн байдал, шударга өрсөлдөх нөхцөл, Зохицуулах хорооны үйл ажиллагаа, засаглал, чадамж, ил тод нээлттэй байдлыг тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн зүгээс хэрхэн үнэлж, дүгнэж байгаа болон тэдэнд тулгарч байгаа бэрхшээл, санал сэтгэгдлийг авч үзлээ.

Судалгааны үр дүнгээр сэтгэл ханамжийн ерөнхий дундаж үнэлгээ 3.9 оноогоор үнэлэгдсэн нь 2018 оны дүнтэй харьцуулахад 0.1 оноогоор сайжирсан дүн байв. Гэхдээ сэтгэл ханамжийн түвшин нь ач холбогдлын түвшнээс 0.4 оноогоор бага байгаа нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүлээлтэд ХХЗХ-оос хүргэж буй үйлчилгээ бүрэн хүрэхгүй байгааг илэрхийлж байна.


Сэтгэл ханамжийн түвшин, өмнөх онтой харьцуулахад

Сэтгэл ханамжийн ерөнхий үнэлгээ, 2022



Сэтгэл ханамжийг тодорхойлохдоо **Тусгай зөвшөөрөл, Зохицуулах хорооны үйл ажиллагаа, Харилцаа холбооны салбарын бодлого зохицуулалт, тусгай зөвшөөрлийн төрөл тус бүрийн үйлчилгээний зохицуулалт** гэсэн 4 дэд үзүүлэлтийн хүрээнд үнэлгээг тооцсон.

Сэтгэл ханамжийн ерөнхий үнэлгээ, дэд үзүүлэлт тус бүрээр




⁸ Судалгааг гүйцэтгэгч: Эс Ай Си Эй ХХК

Дэд үзүүлэлт тус бүрээр сэтгэл ханамжийн үнэлгээг авч үзвэл ерөнхийдөө ойролцоо бөгөөд Харилцаа холбооны салбарын бодлого, зохицуулалтад өгсөн үнэлгээ дунджаас доогуур 3.8, мөн ач холбогдлын түвшнээс 0.5 буюу хамгийн их зөрүүтэй байна. Бодлого, зохицуулалттай холбоотой үнэлгээ бага гарахад харилцаа холбооны салбарт хэрэгжүүлж буй зохицуулалтын арга хэмжээнүүд нь шударга өрсөлдөх нөхцөл бүрдүүлж буй байдал (3.4), зах зээлд зүй ёсны монопол, давамгайл байдалтай аж ахуйн нэгжийн үйлчилгээний тарифын зохицуулалтын оновчтой байдал (3.4), инновац, шинэ үйлчилгээ нэвтрүүлэхэд зохицуулалтын уян хатан байдал (3.6), шинээр гарч буй техник, технологийг судалж зохицуулалтын санал боловсруулж буй байдалд (3.6) өгсөн сэтгэл ханамжийн үнэлгээ нөлөөлсөн байна.

Сэтгэл ханамжийн үнэлгээг тусгай зөвшөөрлийн төрлөөр нь авч үзвэл яриа, интернэт, сүлжээ дэд бүтэц угсралтын тусгай зөвшөөрөл болон тусгай дугаарын бүртгэлтэй үйлчилгээ эрхлэгчид дунджаас бага сэтгэл ханамжтай байна.

Сэтгэл ханамжийн ерөнхий үнэлгээ, тусгай зөвшөөрлийн төрлөөр



Яриа, интернэтийн үйлчилгээ эрхлэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээ бага гарахад давамгайллагчийн үйлчилгээний тарифын зохицуулалт, дугаарын зохицуулалтын оновчтой байдал, салбар хоорондын зохицуулалт хийж буй байдал болон сүлжээний стандартын хэрэгжилтэд өгсөн үнэлгээ нөлөөлсөн бол сүлжээ дэд бүтэц угсралтын тусгай зөвшөөрөл болон тусгай дугаарын бүртгэлтэй үйлчилгээ эрхлэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээ бага гарахад харилцаа холбооны тухай хууль, эрх зүйн орчны шинэчлэлт, өөрчлөлтийг мэдээлж таниулах, соён гэгээрүүлэх байдал дутмаг байгаа нь нөлөөлсөн байна.

Тус хороо нь стратеги зорилтууд, хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлохдоо энэхүү сэтгэл ханамжийн судалгааны дүнд онцгойлон ач холбогдол өгч, сэтгэл ханамжийн дундаж үзүүлэлтийг дээшлүүлэхээс гадна бага үнэлгээ авсан үзүүлэлт тус бүрийн шалтгааныг арилгах, сайжруулахад анхаарч байна. Мөн энэхүү судалгааны бас нэг онцлог нь харилцагчийн сэтгэл ханамжийг удирдах үзүүлэлтүүдийг тодорхойлсон бөгөөд эдгээр үзүүлэлтүүд нь сайн үнэлгээ авсан ч үнэлгээгээ тогтоон барихад анхаарал хандуулах болно.

1.2 ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН, САЛБАРЫН БОДЛОГО

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Сүүлийн 3 жилд Харилцаа холбооны салбарын хууль, эрхзүйн орчинд томоохон өөрчлөлтүүд орсон, мөн 2017 оноос Захиргааны ерөнхий хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой тус хороо нь Зохицуулалтын шаардлага, баримт бичгүүдээ Захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн санд бүртгүүлэх шаардлага үүссэн.

2019 онд Харилцаа холбооны тухай хууль болон салбарын бусад⁹ хуулиудад орсон нэмэлт өөрчлөлт орсон, 2022 онд Цахим хөгжлийн багц хуулиуд (Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хууль), Зөвшөөрлийн тухай хууль шинээр болон шинэчлэгдэн батлагдсантай холбоотой Харилцаа холбооны зохицуулах хороо нь дараах бүрэн эрх, эрх, үүргийг хуулиар нэмж авсан байна. Үүнд:

1. Харилцаа холбооны салбарт мөрдөгдөх норматив баримт бичгийг батлах, хэрэгжилтэд хяналт тавих¹⁰
2. Харилцаа холбооны зах зээлд шударга өрсөлдөх нөхцөл бүрдүүлэхтэй холбогдсон журам батлах, хэрэгжилтэд нь хяналт тавих¹¹
3. Домэйн нэрийг бүртгэх, ашиглахтай холбогдсон журам батлах, хэрэгжилтэд нь хяналт тавих¹²
4. Тусгай зөвшөөрөлгүйгээр эрхлэх харилцаа холбооны үйлдвэрлэл, ашиглалт, үйлчилгээг бүртгэхтэй холбогдсон журам батлах¹³
5. Дотоодын хэрэглээний холбооны сүлжээнд зохицуулалт хийх журмыг баталж, хэрэгжилтэнд хяналт тавих¹⁴
6. Зохицуулах хорооны төсөв, ажлын албаны жилийн төлөвлөгөөг батлах¹⁵
7. Шуудангийн харилцан холболтын журмыг баталж, хэрэгжилтийг хангуулах¹⁶
8. Шуудангийн илгээмж хүргэх хугацааг тогтоож, мөрдүүлэх¹⁷
9. Радио долгионы асуудлаарх Харилцаа холбооны зохицуулах хорооны бүрэн эрх¹⁸
10. Нийтийн түлхүүрийн дэд бүтцийн талаар хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх¹⁹

Мөн 2019 оны 12 дугаар сард Өргөн нэвтрүүлгийн тухай хууль шинээр батлагдаж, 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээр Монгол улсад ардчилал үүсч, чөлөөт хэвлэл мэдээллийн хэрэгсэл үүссэнээс хойш анх удаа радио, телевизийн хөтөлбөр буюу агуулгад тусгайлсан хуулиар шаардлага тавих болж өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэхтэй холбоотой эрхзүйн харилцаа шинэ түвшинд гарсан болно. Тус хуулиар өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх эрхзүйн үндсийг тодорхойлсноос гадна зах зээлд шударга өрсөлдөх орчныг бүрдүүлэх, үндэсний болон нийтийн ашиг сонирхолд нийцсэн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах эрхзүйн үндэс тавигдсан юм.

⁹ Радио долгионы тухай хууль, Шуудангийн тухай хууль

¹⁰ Харилцаа холбооны тухай хуулийн 9.1.3

¹¹ Харилцаа холбооны тухай хуулийн 9.1.6

¹² Харилцаа холбооны тухай хуулийн 9.1.14

¹³ Харилцаа холбооны тухай хуулийн 9.1.15

¹⁴ Харилцаа холбооны тухай хуулийн 21.2

¹⁵ Харилцаа холбооны тухай хуулийн 9.1.16

¹⁶ Шуудангийн тухай хуулийн 9.1.5

¹⁷ Шуудангийн тухай хуулийн 9.1.6

¹⁸ Радио долгионы тухай хуулийн 5^o.1

¹⁹ Цахим гарын үсгийн тухай хуулийн 32.1

Ийнхүү Өргөн нэвтрүүлгийн тухай хуулиар Харилцаа холбооны зохицуулах хороонд мэдээллийн хэрэгсэл болсон радио, телевизийн өргөн нэвтрүүлгийн хөтөлбөрт хяналт тавих, өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах чиг үүрэг хүлээлгэсэн болно. Харилцаа холбооны зохицуулах хорооны хувьд Монгол улсад ардчиллын үнэт зүйл болсон үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, олон талт мэдээ, мэдээлэл авах иргэний эрхийг хүндэтгэх хуулийн зорилт, зарчмын хүрээнд өргөн нэвтрүүлгийг хараат бус байлгах, даяаршлын эрин үед Монгол улсын үндэсний болон нийтийн нийтлэх эрх ашгийг радио, телевизийн салбарт хамгаалах зорилт тулгарч байна.

МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ²⁰

Мандат²¹-ын шинжилгээ хийхдээ ЗГХЭГ-ийн даргын 2020 оны 100 дугаар тушаалын Хавсралтаар батлагдсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ыг жишиг болгосон. Энэхүү аргачлалд заасны дагуу мандат нь байгууллагын хуулиар олгосон чиг үүрэг, эрх хэмжээгээр тодорхойлогдох бөгөөд Алсын хараа, Эрхэм зорилгын ажлын хүрээг тогтооно. Мандатыг Монгол улсын хуулиудад тус хороо хариуцан хэрэгжүүлэхээр заасан бүрэн эрх, эрх, үүргүүдийг, Харилцаа холбооны хуулийн зорилт, байгууллагын хуулиар тодорхойлогдсон үндсэн чиг үүрэгтэй хамруулан дараах байдлаар авч үзлээ. Үүнд:

Харилцаа холбооны тухай хуулийн 1.1			
Энэ хуулийн зорилт нь Монгол Улсад харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүнийг ашиглах, хамгаалах, зах зээлийн үр өгөөжтэй, шударга өрсөлдөөнийг дэмжих, иргэн, хуулийн этгээдийг харилцаа холбоо, мэдээллийн технологийн чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээгээр хүртээмжтэй хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.			
ХХЗХ-ны бие даасан байдлын баталгаа	харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүнийг ашиглах, хамгаалах	зах зээлийн үр өгөөжтэй, шударга өрсөлдөөнийг дэмжих	иргэн, хуулийн этгээдийг харилцаа холбоо, мэдээллийн технологийн чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээгээр хүртээмжтэй хангах
Харилцаа холбооны тухай хуулийн 8-р бүлэг	8.1. Өмчийн бүх төрлийн аж ахуйн нэгж, иргэн харилцаа холбооны зах зээлд үр ашигтай, шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх, хуульд заасан тусгай зөвшөөрөл олгох, мэргэжлийн дүгнэлт, шийдвэр гаргах чиг үүрэгтэй Харилцаа холбооны зохицуулах хороо /цаашид "Зохицуулах хороо" гэх/ ажиллана.		
Харилцаа холбооны тухай хуулийн 9.1.1-9.1.16			
ХХ-ны тухай хуулийн 9.1.17	Радио долгионы тухай хууль		
	Өргөн нэвтрүүлгийн тухай хууль		
	Шуудангийн тухай хууль		
	Хүүхэд хамгааллын тухай хууль		
	Цахим гарын үсгийн тухай хууль		
	Сонгуулийн тухай хуулиуд		

²⁰ Дэлгэрэнгүй шинжилгээг Хавсралт 1-ээс үзэх

²¹ Байгууллагын хуулиар олгосон эрх, хэмжээ

Шинжилгээнд хамрагдсан эрх, хэмжээ:

	Мандат авсан хууль	Бүрэн эрх ²²	Эрх, үүрэг ²³
	Үндсэн чиг, үүрэг. Өмчийн бүх төрлийн аж ахуйн нэгж, иргэн харилцаа холбооны зах зээлд үр ашигтай, шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх		
1.	Харилцаа холбооны тухай	16+1	
2.	Радио долгионы тухай хууль	10	
3.	Шуудангийн тухай хууль	5	
4.	Өргөн нэвтрүүлгийн тухай хууль	11	
5.	Хүүхэд хамгааллын тухай хууль		1
6.	Цахим гарын үсгийн тухай хууль		6
7.	Сонгуулийн тухай хуулиуд		27

САЛБАРЫН БОДЛОГО

Өмнө нь харилцаа холбооны талаарх төрийн захиргааны асуудлыг Харилцаа холбоо мэдээлэл технологийн газар, Засгийн газрын тохируулагч агентлаг, эрхэлдэг байсан бол 2021 оны 11 сард Монгол улсын Засгийн газрын тухай хууль, Монгол улсын яамны эрхзүйн байдлын тухай, Харилцаа холбооны тухай хуулиудад нэмэлт өөрчлөлт орсноор Цахим хөгжил харилцаа холбооны яам байгуулагдан 2022 оны 01 сарын 01-ээс үйл ажиллагаагаа эхлүүлж, “Алсын хараа – 2050”, Засгийн газрын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт олон улсад өрсөлдөх чадвар бүхий үндэсний шинжлэх ухаан, технологи, инновацыг хөгжүүлэх замаар эдийн засгийн тэргүүлэх чиглэлийн нэг болгох зорилт тавьж, “Цахим Үндэстэн” болох уриалгыг дэвшүүлж, дараах 6 зорилтыг баталсан байна. Үүнд:

1. **ДИЖИТАЛ ДЭД БҮТЭЦ**, Мэдээллийн технологи, харилцаа холбооны өсөн нэмэгдэх хэрэгцээ шаардлагыг хангахуйц суурь дэд бүтцийн бэлэн байдлыг хангана.
2. **ЦАХИМ ЗАСАГЛАЛ**, Нийгэм, эдийн засгийн бүх салбарт харилцаа холбоо, мэдээллийн технологи, инновацыг нэвтрүүлж, бүтээмж, өрсөлдөх чадвар, үр ашгийг нэмэгдүүлэх замаар хүнд сурталгүй, ил тод цахим засаглалыг бүрдүүлнэ.
3. **МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ**, Цахим орчинд үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоог бүрдүүлэн, орчин үеийн техник технологийг нэвтрүүлэн, төр, хувийн хэвшил, иргэний мэдээллийн аюулгүй байдлын мэдлэг, ойлголтыг дээшлүүлж, мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг хангана.
4. **ТООН БИЧИГ ҮСГИЙН ЧАДАВХИ**, Бүх нийтийн тоон бичиг үсгийн чадавхыг дээшлүүлэн, тоон хуваагдлыг арилгаснаар Цахим үндэстэн болно.
5. **ИННОВАЦИ ҮЙЛДВЭРЛЭЛ**, Мэдээллийн технологи, их өгөгдөл, хиймэл оюун ухаан, блокчэйнд суурилсан платформууд, программ хангамж, үндэсний тоон контентыг хөгжүүлж, газрын ховор элементэд түшиглэн электроникийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, экспортод гарган эдийн засгийн шинэ секторыг хөгжүүлнэ.
6. **ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ХУРДАСГУУР**, Нийгэм, эдийн засгийн салбарт харилцаа холбоо, мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлж, өрсөлдөх чадвар, бүтээмж, үр өгөөжийг дээшлүүлнэ.

²² Хүчинтэй

²³ Хүчинтэй

1.3 ТЕХНОЛОГИ, ИННОВАЦИ²⁴

Харилцаа холбоо, мэдээллийн технологи нь олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн стандарт хөгжүүлэгч байгууллагуудын тогтоосон стандартад нийцүүлэн, технологи үйлдвэрлэгчид (vendors) сүлжээ, үйлчилгээ болгон биежүүлж, үйлчилгээ эрхлэгчид хэрэглэгчийн бүтээгдэхүүн хүргэдэг, стандартууд нь хурдацтайгаар өөрчлөгдөн хөгждөг, хөгжих тусам эдийн засаг, нийгмийн бусад салбаруудад нэвтэрч байгаа технологи, инновацийн салбар билээ.

Гар утас нь нэгэнт хүний амьдралын салшгүй хэсэг болжээ. Гар утас болон бусад хөдөлгөөнт төхөөрөмжөөр дамжуулан хүмүүс байнгын холболттой байж, төрөл бүрийн апп, дижитал хэрэгслийн тусламжтай өдөр тутмын амьдралыг хөнгөвчлөх, тав тухыг олохын зэрэгцээ ХАА, Тээвэр ложистик, аялал жуулчлал, боловсруулах үйлдвэрүүд, эрчим хүчний зэрэг нийгэм эдийн засгийн гол салбаруудад автоматжуулалт, дижитал шилжилтийн боломжийг нээж өгч байна.

Дэлхий нийтээр утасгүй холбооны 5G сүлжээ, түүний нээж байгаа боломжууд, эдийн засаг нийгмийн үр ашгийг онцолж байгаа бөгөөд нэвтрүүлэхээр зорьж байгаатай ижил ХХЗХ-ны стратеги нь мөн энэхүү технологи, түүнийг дагаж үүсч байгаа хэрэглээний технологиуд, дагалдах зохицуулалтын чиг хандлагыг онцолж байна.

УТАСГҮЙ ХОЛБООНЫ ДАРАА ҮЕИЙН СҮЛЖЭЭ (5G), 5G СҮЛЖЭЭГ НЭВТРҮҮЛЭХЭД МОНГОЛ УЛСЫН БЭЛЭН БАЙДАЛ, ҮР АШИГ

2022 оны 2 сард ОУЦХБ-аас Монгол улс 5G сүлжээг нэвтрүүлэхэд зах зээлийн бэлэн байдал, зохицуулалтад гарах сорилтуудыг үнэлсэн.

Хөдөлгөөнт холбооны 5G сүлжээг нэвтрүүлэхэд спектр хангалттай биш байх, дэд бүтцийн суурилалт, үр ашиг гэх мэт хүндрэлүүд байгаа хэдий ч дижитал шилжилт, автоматжуулалт, анализ, манай салбарын нийгэм эдийн засгийн бусад салбаруудтай хамтын ажиллагаа, шинэ тутам бизнесүүд нь стратегийн болон ойрын хугацаанд өргөн боломжийг нээж өгнө. Гэхдээ эдгээр боломжууд нь тухайн улс орны эдийн засаг, гол салбаруудын хүсэл зориг, ойлголтоос хамаарч өөр байх бол дэд бүтцийн бэлэн байдал, үйлчилгээ, хэрэглэгчийн базаас хамааран 5G-ийн бий болгох үр ашиг нь оператор тус бүрт өөр өөр байна.

УТАСГҮЙ СУУРИН ХАНДАЛТ (FWA)-ААР ДИЖИТАЛ ХУВААГДЛЫГ АРИЛГАХ

Өндөр хурдтай, найдвартай интернет нь улс орнуудыг дижитал хуваагдал, ялгаатай байдлыг багасгахад туслах бөгөөд 5G стандартын FWA технологийн дамжуулах чадвар нь суурин өргөн зурвасын үйлчилгээ хүрээгүй газар нутаг, хүн амд дахь найдвартай, өндөр хурдтай интернетийн хэрэгцээг нөхнө. Норвегийн Телиа, Финландын Телеонор нарын зарим операторууд, 5G FWA-г шилэн кабелиас бага зардалтай мөртлөө, харьцуулагдахуйц хурдтай байна гэж үзээд DSL үйлчилгээний оронд 5G FWA-ыг санал болгох болсон.

Зарим операторууд хөдөө орон нутгийн иргэд, ялангуяа утастай технологи ашиглах боломжгүй, хүндрэлтэй газар нутагт суурин өргөн зурвасын үйлчилгээг 5G-ээр хүргэж байна. Тухайлбал, 5G FWA-д 700МГц зэрэг нам давтамжийн спектр ашиглах нь хүн ам сийрэг суурьшдаг газар нутагт өндөр хурдны өргөн зурвасын үйлчилгээ хүргэхэд нутгийн иргэдэд зайны боловсрол, эмнэлэг зэрэг нийгмийн үйлчилгээ хүргэх, ухаалаг аж ахуйг дэмжих гэх мэтээр амьдралын чанарыг нь сайжруулахаас гадна операторуудад бизнесийн ашигтай байна. 2021 оны байдлаар, 5G FWA-ыг

²⁴ ОУЦХБ-ын судалгааны материал, баримт бичгүүдийг эх үүсвэр болгосон

гэрийн болон байгууллагад зориулсан бүтээгдэхүүнээр санал болгож байгаа операторын тоо 81 байгаа нь жилийн өмнөхөөс 44-өөр нэмэгдсэн бөгөөд эдгээр нь 50Mbps-ээс 2Gbps хурд²⁵ыг санал болгож байна²⁶.

ВИРТУАЛ СҮЛЖЭЭ БА ЗАРДЛЫН ҮР АШИГТАЙ БАЙДАЛ

Дэлхий даяар, дата ачаалал хурдтай өсч байгаа хандлага, ялангуяа цар тахлаас хойш тогтмол ажиглагдаж байгаа бөгөөд операторууд хэрэглээний практик²⁷ийг хадгалахын тулд байнга сүлжээгээ өргөтгөн сайжруулж байна. Зарим операторууд, 5G-ийн модуляци, кодчлол, массив ММО, кареер нэгтгэл²⁸ шийдлүүд нь ачааллын өсөлтөөр өргөтгөл хийхэд хамгийн үр ашигтай байна гэж тооцож байна.

LTE-г LTE-Advanced-ээр сайжруулж байсан шиг, 3GPP 5G-Advanced стандарт (Release 18) дээр ажиллаж байгаа бөгөөд хэрэглэгчийн төхөөрөмжийн хүчин чадлыг бууруулах, AI, ML-ын чадавхийг нэмэгдүүлэх замаар эрчим хүчний хэмнэлт, үр ашиг, байршлын нарийвчлал, хамрах хүрээ зэрэг үзүүлэлтийг илүү сайжруулахыг зорьж байна. Ойрын 1, 2 жилдээ технологи болж гарахгүй ч сайжрах роаппап нь тодорхой байгаа.

Операторууд сүлжээний гүйцэтгэл²⁹, үр ашгаа сайжруулах үр ашигтай, хэмнэлттэй арга замыг байнга эрэлхийлж байдаг бөгөөд 5G-ийн виртуал болон нээлттэй RAN нь хардвэрын хэрэгцээг багасгасанаар уян хатан, үр ашигтай байдлыг нэмэгдүүлнэ. Мөн кор³⁰оо клөүд дээр байршуулах боломжтой болж байгаа гэх мэтчилсэн 5Gд сүлжээний зохион байгуулалт маш уян хатан болохын сацуу сүлжээ төлөвлөлт, зохион байгуулалтыг илүү ухаалаг байхыг шаардана гэсэн үг. Майкрософт операторуудад зориулсан бүтээгдэхүүн³¹ гаргасан бөгөөд AT&T жишээлэхэд, сүлжээний бүтээмж, зардлын үр ашгийн зорилгоор, 5G сүлжээгээ шилжүүлнэ гэж зарласан.

Өөрөөр хэлбэл, 5G нь операторуудыг үр ашигтай, хөрөнгө оруулалт бага шаардах сүлжээний загвараар ашиглах боломжоор хангаж байгаа бөгөөд 5G сүлжээ байгуулахад зардлын үр ашигтай, оновтой удирдахын тулд операторууд пассив төдийгүй, актив дэд бүтцээ аль болох хамтран ашиглах зохицуулалт нь улам бүр шаардлагатай болж байна.

Идэвхтэй дэд бүтэц хамтран ашиглах шийдлүүд аль хэдийн хөгжүүлэгдсэн бөгөөд жишээлбэл, MORAN³² шийдэлтэй үед операторууд дундын RAN-тай байх бөгөөд өөр, өөрсдийн давтамжийн цараан ажиллах бол MOCN³³ нь шийдэл нь операторууд RAN болон спектрээ хуваалцах боломжийг бүрдүүлсэн.

ШИНЭЭР ГАРЧ ИРЖ БУЙ (EMERGING) ТЕХНОЛОГИУД, ЗОХИЦУУЛАЛТ

Тоон шилжилт, харилцаа холбооны дараа үеийн технологиуд нь хүмүүс төдийгүй юмсыг холбож, асар их өгөгдлийг бий болгохын хэрээр түүнийг удирдах технологиуд шинээр гарч ирж

²⁵ Downlink

²⁶ GSA

²⁷ User experience

²⁸ Carrier aggregation

²⁹ Performance


³⁰ Core

³¹ Azure

³² Multi-operator RAN

³³ Multi-operator core

байгаа бөгөөд эдгээр нь зохицуулагчдаас зах зээлд шударга өрсөлдөөн бүрдүүлэх, хэрэглэгчдийг хамгаалах арга механизмаа эргэж харахыг шаардаж байна.



Зураг 1. Өгөгдөл удирдахтай холбоотой шинээр гарч ирж буй технологиуд



Зураг. Дижитал эдийн засгийн бүрдүүлэгч гол салбарууд

Эдгээр технологиуд нь хэдийгээр харилцаа холбоо, Internet Value Chain-ийн хэсэг ч IoT-аас бусдад нь одоогоор харилцаа холбооны салбарын зохицуулалт үйлчилдэггүй бөгөөд зохицуулалтын асуудал нь хэрэглээнээсээ хамаарсан бөгөөд олон улсын хууль эрх зүйн хүрээний өгөгдөл хамгаалах, хэрэглэгчийн эрхийн асуудал байдаг.

Дээрх өгөгдлийн технологиуд нь инновацийг хөнгөвчлөх, төрийн үйлчилгээг оновчтой болгох, уул уурхайгаас хамааралтай эдийн засгийг төрөлжүүлэхэд Харилцаа холбоо, мэдээллийн технологийг ашиглах, дижитал эдийн засгийг хөгжүүлэхэд манай улсад маш том дэмжлэг болох бөгөөд “Цахим Үндэстэн” хөтөлбөр нь яг энийг зорилго болгон Монгол Улсын дижитал эдийн засагт чухал ач холбогдолтой гол салбаруудыг тодорхойлсон байна. Өөрөөр хэлбэл, эдгээр өгөгдлийн технологиудын, нийгэм эдийн засгийн бусад гол салбаруудад бий болгож байгаа боломжуудыг төрийн бодлогын хүрээнд үр ашигтай, өгөөжтэй шийдлүүд болгох чиглэлээр оролцогч талуудын хамтын ажиллагаа чухал байна.

ҮНДСЭН СҮЛЖЭЭНИЙ (BACKBONE) ХӨГЖИЛ, ЗОХИЦУУЛАЛТ

Монгол Улсын харилцаа холбооны сүлжээний зохицуулалт 2005 оноос зах зээлийн монополь байдлыг задлах, сүлжээ, үйлчилгээг салган ялгаатай зохицуулах, зах зээлд шинээр үйлчилгээ эрхлэгч нэвтрүүлж, өрсөлдөөнд суурилсан бизнесийн зарчмаар хувийн хэвшлийн оролцоотойгоор сүлжээний хамрах хүрээг нэмэгдүүлэхэд чиглэж байсан. бол 2014 оноос байгуулсан сүлжээний үр ашигтай байдлыг нэмэгдүүлэх, эдийн засгийн өгөөж бий болгох, хөрөнгө оруулалтыг хэмнэх, оновчтой чиглүүлэх, сүлжээг нээлттэй болгоход чиглэж байна.

Монгол Улсын үндсэн сүлжээ нь технологийн хувьд шилэн кабелийн болон сансрын холбооны сүлжээнээс бүрддэг. Сансрын холбооны сүлжээг шилэн кабелийн сүлжээ хүрээгүй цэгт үүрэн холбооны яриа, мессежний үйлчилгээ хүргэх зорилгоор ашиглаж байна. Монгол Улсын хэмжээнд аймгийн төв, сум хоорондын шилэн кабелийн сүлжээг тус хорооноос тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүд байгуулж байгаа бөгөөд уг сүлжээг бусад хэрэглэгчдэд түрээсийн зарчмаар ашиглуулж байна. Харин хот суурин газрын сүлжээг сүлжээ байгуулах болон үйлчилгээ

эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээдүүд нийтийн үйлчилгээний зориулалтаар, иргэн, аж ахуйн нэгж дотоод хэрэгцээний зориулалтаар тус тус байгуулж байна.

Сүлжээний зохицуулалтын эхний үе шат буюу зах зээлийг тэлэх зохицуулалтын үр дүнд Монгол Улсын шилэн кабелийн сүлжээний нийт урт 2021 оны жилийн эцсийн байдлаар 47278 км-т хүрээд байна. Уг сүлжээний хүртээмжийг засаг захиргааны нэгжийн хувьд авч үзвэл улсын хэмжээний 330 сумаас 325 сум, нийт 1810 багаас 1710 гаруй баг шилэн кабелийн сүлжээнд холбогдоод байна. Шилэн кабелийн сүлжээ хүрээгүй 5 суманд Засгийн Газрын бодлогоор олон улсын зээл тусламжийн хүрээнд шилэн кабелийн сүлжээ хүргэх ажлууд хийгдэж байна.

Дэд бүтцийн зохицуулалтын хувьд МХС ХХК нь худаг, сувагчлалын үйлчилгээн дээр монополь бөгөөд 2022 оны эхний хагас жилийн байдлаар худаг сувагчлалын үйлчилгээг 122 аж ахуйн нэгжид үзүүлж байна. Монгол Улсын хэмжээнд 13716 ширхэг худаг, 1030.6 километр сувагчлал, 21072 агаарын багана байна.

Цаашид Зохицуулах хорооны зүгээс сүлжээний зохицуулалтын дараагийн шатанд гаргаж, сүлжээний үр ашигтай байдлыг нэмэгдүүлэх, эдийн засгийн өгөөж бий болгох, хөрөнгө оруулалтыг хэмнэх, оновчтой чиглүүлэхийн зэрэгцээ хот суурин газрын, хэрэглэгчийн сүлжээг нээлттэй болгох, шинээр бий болж буй дараа үеийн үйлчилгээнүүдийг дэмжсэн нарийвчилсан зохицуулалтуудыг хийх шаардлага гарч байна.

2 АЛСЫН ХАРАА, ЭРХЭМ ЗОРИЛГО, СТРАТЕГИ ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД

Бид Алсын хараа, Эрхэм зорилго, зорилго, зорилгоо тодорхойлохдоо хуулиар олгогдсон эрх, хэмжээний хүрээнд “Алсын Хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Цахим Үндэстэн” Үндэсний хөтөлбөр, Цахим хөгжил харилцаа холбооны яамны стратеги-д өөрийн байгууллагын оролцоог тодорхойлохоос эхэлсэн. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуульд заасан зарчмуудыг баримтлахын сацуу стратеги удирдлагын сайн хэрэгслүүд, нийтлэг бүрэлдэхүүнийг удирдлага болгов.

АЛСЫН ХАРАА

Дижитал шилжилт³⁴ийг дэмжих, баримтад суурилсан, уян хатан, хамтын зохицуулалттай 5 дахь үеийн³⁵ зохицуулах байгууллага болно.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Бид Харилцаа холбоо³⁶-ны чанартай, дэвшилтэт бүтээгдэхүүн, үйлчилгээгээр хэрэглэгчийг хүртээмжтэй хангах, оролцогч талууд харилцан үр ашигтай хамтран ажиллах зохицуулалтын тогтолцоог төгөлдөршүүлнэ.

ҮНЭТ ЗҮЙЛ

СУУРЬ ЗАРЧИМ:

Үндэсний эрх ашиг, хуулиа дээдлэн бие даасан, ил тод, хараат бус зарчмыг баримтлан дараах үнэт зүйлийг төлөвшүүлнэ:

ҮНЭТ ЗҮЙЛ:

1. Ёс зүйтэй, шударга, зарчимч (Ethics, integrity)

Зохицуулах хорооны ажилтны ёсзүйн дүрмийг мөрдөж, хариуцсан ажил, гаргасан шийдвэртээ эзэн байна.

2. Мэргэшсэн, өндөр чадавхитай (Professional)

Зохицуулагчийн эзэмшвэл зохих болон стратеги зорилтуудыг хэрэгжүүлэхэд нэн шаардлагатай мэдлэг, ур чадварыг эзэмшиж, өөрийгөө болон бусдыг хөгжүүлнэ.

- Зохицуулагчийн ур чадвар³⁷

- Дата литерэси, дата анализ

- Дижитал ур чадвар

- Төслийн удирдлага

3. Тасралтгүй суралцагч (Continues learning)

Ажиллагсдын суралцах үйл явцыг байнга дэмжиж, өөрчлөлтөд дасан зохицох чадвартай, суралцагч байгууллага байна.

4. Хариуцлагатай (Commitment)

Байгууллага нь хамт олон болон тэдний гэр бүл, нийгмийн өмнө, ажилтан нь мөн өөрийн гэр бүл, нийгмийн өмнө хүлээсэн үүргээ ухамсарлаж хариуцлагатай байна.

³⁴ Дижитал шилжилт нь зөвхөн технологийн асуудал биш бөгөөд цахим технологи, сүлжээ, үйлчилгээг үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлэх тухай цогц үйл явц юм.

³⁵ 5 дахь үеийн зохицуулалт гэдэг нь зохицуулалтыг төр-бизнес, салбар болон салбар хооронд өргөн хүрээнд ил тод хүлээн зөвшөөрөгдөхүйц хэрэгжүүлэхийг ойлгоно.

³⁶ “Харилцаа холбоо” гэж цахилгаан холбоо, радио телевиз, шуудангийн бүх төрлийг;

³⁷ Үр ашигтай зохицуулалт хэрэгжүүлэхэд нэн түрүүнд шаардлагатай бодлого, зохицуулалтын хүрээ, арга хэрэгслүүдийг ойлгох, тэдгээрийг ашиглах, зохицуулалтын шилдэг туршлагыг нэвтрүүлэх гэх мэт цогц ур чадварыг ойлгоно.

СТРАТЕГИ ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД

Бид 3 стратегийн зорилго буюу зохицуулалтыг тэргүүлэх чиглэлийг тодорхойлсон бөгөөд стратегийн зорилгуудаа удирдахын тулд тэнцвэржүүлсэн үнэлгээний жишгээр үйл ажиллагааны зорилтуудыг тодорхойллоо.

Алсын хараа:		
Эрхэм зорилго:		
Суурь зарчим/Үнэт зүйл:		
Стратеги зорилго 1	Стратеги зорилго 2	Стратеги зорилго 3
Өсөн нэмэгдэж буй хэрэгцээг хангах тэгш, хүртээмжтэй харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийг хөгжүүлнэ.	Харилцаа холбооны салбарт өрсөлдөөн, инновацийг дэмжиж, цахим үйлчилгээ хөгжих орчныг бүрдүүлнэ	Харилцаа холбоо, өргөн нэвтрүүлгийн үйлчилгээг Монгол хүн бүрт чанартай, хүртээмжтэй хүргэнэ
Стратегийн зорилгуудыг удирдах дэмжих үйл ажиллагаа		
1. Зохицуулалтын үйлчилгээний ил тод, шуурхай байдлыг нэмэгдүүлэх		
2. Санхүүгийн зохистой харьцааг хангах, үр ашийг нэмэгдүүлэх		
3. Байгууллага үнэ цэнэтэй капиталаа нэмэгдүүлэх замаар чадамжаа байнга дээшлүүлж, бүтээмж дэмжсэн суралцагч байгууллага болох		

СТРАТЕГИ ЗОРИЛГО 1. ӨСӨН НЭМЭГДЭЖ БУЙ ХЭРЭГЦЭЭГ ХАНГАХ ТЭГШ, ХҮРТЭЭМЖТЭЙ ХАРИЛЦАА ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ, ДЭД БҮТЦИЙГ³⁸ ХӨГЖҮҮЛНЭ.

Хэрэглэгч бүр хаана байгаагаас үл хамаарч өндөр чанартай, уян хатан, хамгийн сүүлийн үеийн, ухаалаг, дижитал/цахим дэд бүтцэд холбогдож, цахим үйлчилгээ авах боломжийг бүрдүүлснээр Мэдээлэл технологийн дэвшлийг ашиглах³⁹ үндэсний бодлогын зорилтыг дэмжих бөгөөд энэ тус хорооны ирэх 3 жилийн стратегийн нэн тэргүүлэх зорилт байна.

Харилцаа холбоо, мэдээллийн технологиор эдийн засгийг дэмжих, дижитал эдийн засгийг хөгжүүлэх үндэс нь найдвартай, хүртээмжтэй дэд бүтэц, холболт бөгөөд зах зээлийн эрэлт хэрэгцээ, судалгаанд үндэслэн дараах зохицуулалтыг хэрэгжүүлнэ. Үүнд:

СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 1. ӨСӨН НЭМЭГДЭЖ БУЙ ХЭРЭГЦЭЭГ ХАНГАХ ТЭГШ, ХҮРТЭЭМЖТЭЙ ХАРИЛЦАА ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ, ДЭД БҮТЦИЙГ ХӨГЖҮҮЛНЭ.		
ЗОРИЛТ 1.1	ЗОРИЛТ 1.2	ЗОРИЛТ 1.3
Сүлжээний бүсчилсэн топологи, сүлжээний үйлчилгээний газарзүйн ялгаваргүй тарифын зохицуулалт хэрэгжүүлэх	Нээлттэй сүлжээний зарчим, дэд бүтэц хамтран ашиглах зохицуулалт хэрэгжүүлэх	Шуудангийн харилцан холболтыг нэмэгдүүлэх, бүсчилсэн тогтолцоо нэвтрүүлэх замаар шуудангийн сүлжээний ашиглалтыг нэмэгдүүлэх
<ol style="list-style-type: none">1. Зохицуулалтын шийдвэрт ашиглагдагдах судалгаа, өгөгдлийн чадавхийг сайжруулах2. Хязгаарлагдмал нөөц, Зохицуулалтын бодлогын нэгдмэл байдлыг хангах3. Тусгай зөвшөөрлийн гэрээний үүрэг хэрэгжүүлэх тогтолцоог төгөлдөршүүлэх		



Зорилт тус бүрийг хангах нэгдмэл уялдаатай дэд төлөвлөлтүүд хэрэгжих ба Зохицуулалтын шийдвэрийн үр нөлөөтэй байдлыг зохицуулалтад нийтлэг ашиглагддаг, сайн туршлагад үндэслэн үнэлэх зарчмаар Стратегийн хэрэгжилтийг үнэлнэ.

ХҮРЭХ ҮР ДҮН (OUTPUT): ТЭГШ ХҮРТЭЭМЖТЭЙ ДЭД БҮТЭЦ

³⁸ Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтэц гэдэг нь дижитал холболт буюу бүх төрлийн дижитал үйлчилгээг өндөр чанартайгаар хүлээн авах боломжит дэд бүтэц, платформ, аппликэйшн, төхөөрөмжийн цогц боломж нөхцөл бүрдсэн байхыг ойлгоно.

³⁹ “Алсын хараа-2050” урт хугацааны бодлогын баримт бичиг

СТРАТЕГИ ЗОРИЛГО 2. ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЛБАРТ ӨРСӨЛДӨӨН, ИННОВАЦИЙГ ДЭМЖИН, ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭ ХӨГЖИХ ОРЧИН НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛНЭ.

Харилцаа холбооны салбарын хөгжлийг эрчимжүүлснээр бусад салбарт цахим үйлчилгээ хөгжих орчин нөхцлийг бүрдүүлж, дижитал эдийн засгийн өсөлтийг дэмжиж, “Дижитал эдийн засгийг хөгжүүлэх⁴⁰” үндэсний зорилт хангагдах тулгуур болох ба Стратегийн зорилго 2-ын хүрээнд харилцан уялдаатай, өрсөлдөөний нөхцөл байдалд үндэслэсэн, зах зээлийн эрэлт, инновацийн хэрэгцээг хангахад чиглэсэн дараах зорилтуудыг хэрэгцүүлнэ.

СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 2. ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЛБАРТ ӨРСӨЛДӨӨН, ИННОВАЦИЙГ ДЭМЖИН, ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭ ХӨГЖИХ ОРЧИН НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛНЭ.				
ЗОРИЛТ 2.1	ЗОРИЛТ 2.2	ЗОРИЛТ 2.3	ЗОРИЛТ 2.4	ЗОРИЛТ 2.5
Дараа үеийн холболт, харилцан холболтын зохицуулалт, нээлттэй сүлжээний зарчмыг нэвтрүүлэх	Хязгаарлагдмал нөөц (Радио давтамж, Дугаар) - ийг үр ашигтай удирдаж, шинэ технологи, инновацийн хэрэгцээ, ил тод байдлыг хангах	Хэрэглэгчийн сүлжээ, төгсгөлийн төхөөрөмжийн нэгдсэн стандарт хэрэгжүүлэх замаар хэрэглэгчийн сонголтыг чөлөөтэй болгох	ӨН-ийн хараат бус нээлттэй байдлыг хангах, хэт төвлөрөл үүсэхээс сэргийлэх зохицуулалт хэрэгжүүлэх	Шуудангийн зардлыг бууруулах, үр ашгийг нэмэгдүүлэх
<ol style="list-style-type: none"> 1. Зохицуулалтын бодлогыг тодорхойлох, шинэчлэх 2. Эдийн засгийн болон техникийн зохицуулалт (радио давтамжийн болон харилцан холболтын техникийн асуудлууд)-ын уялдааг хангах, нээлттэй ил тод байдлыг хангах, шинэ технологи нэвтрэх саадыг бууруулах 				



Зорилт тус бүрийг хангах нэгдмэл уялдаатай дэд төлөвлөлтүүд хэрэгжих ба Зохицуулалтын шийдвэрийн үр нөлөөтэй байдлыг зохицуулалтад нийтлэг ашиглагддаг, сайн туршлагад үндэслэн үнэлэх зарчмаар Стратегийн хэрэгжилтийг үнэлнэ.

ХҮРЭХ ҮР ДҮН (OUTPUT): ЗАХ ЗЭЭЛИЙН ТААТАЙ ОРЧИН, ҮР АШИГТАЙ ХОЛБОЛТ

⁴⁰ Цахим Үндэстэн, үндэсний хөтөлбөр

СТРАТЕГИ ЗОРИЛГО 3. ХАРИЛЦАА ХОЛБОО, ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ЧАНАРТАЙ, ХҮРТЭЭМЖТЭЙ ХҮРГЭХ НӨХЦЛИЙГ БҮРДҮҮЛНЭ.

1. Чанартай, хүртээмжтэй цахим үйлчилгээ хэрэглээнд нэвтэрсэнээр хэрэглэгчийн өдөр тутмын амьдралыг хөнгөвчилж, “Монгол хүний амьдралын чанарыг дээшлүүлэх” үндэсний зорилтыг хангахад дэмжлэг үзүүлнэ.
2. Үндэсний болон олон нийтийн эрх ашигт нийцсэн, хараат бус өргөн нэвтрүүлгийн хөтөлбөрийн үр дүнд өргөн нэвтрүүлгийн орчинд үндэсний дархлааг хамгаалах, ард иргэд олон талт, тэнцвэртэй мэдээлэл хүлээн авах иргэний эрхийг хангахад хувь нэмэр оруулна.

Стратегийн 3-р зорилгыг хэрэгжүүлэхдээ дараах үйл ажиллагааны зорилтууд хэрэгжүүлэх бөгөөд байгууллага нийгмийн хариуцлага, тогтвортой хөгжлийн зорилгоор Харилцаа холбооны үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх зохицуулалт хэрэгжүүлэхдээ хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэгш үйлчлүүлэх боломжийг хангах, харилцаа холбооны технологи, инновацийн хүний амьдрах орчин, байгальд ээлтэй байх амьдралын чанарыг дордуулах нөхцөл болохгүй байх талаас нь үргэлж анхаарч ажиллана.

СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 3. ХАРИЛЦАА ХОЛБОО, ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ЧАНАРТАЙ, ХҮРТЭЭМЖТЭЙ ХҮРГЭХ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛНЭ.

ЗОРИЛТ 3.1 Харилцаа холбооны үйлчилгээний чанарын хяналтын нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх	ЗОРИЛТ 3.1 Харилцаа холбооны тоног төхөөрөмжийн баталгаажуу-лалтын тогтолцоонд лабораторийн баталгаажуулалт нэвтрүүлэх	ЗОРИЛТ 3.1 Үндэсний радио долгионы хяналтын үйл ажиллагааг бүсчилсэн тогтолцоонд үе шаттайгаар шилжүүлэх	ЗОРИЛТ 3.1 Шуудангийн нэгдсэн кодыг хэрэглээнд төлөвшүүлэх	ЗОРИЛТ 3.1 Өргөн нэвтрүүлгийн орчинд үндэсний дархлааг хамгаалах, олон нийтийн нийтлэг эрх ашиг, үзэгч, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах	ЗОРИЛТ 3.1 Цахим орчинд хүүхдийн эрх, олон нийтийн нийтлэг эрх ашгийг хамгаалах
--	--	--	--	---	---

1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн харилцаа холбооны үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх
2. Хүний аюулгүй амьдрах орчин, байгальд ээлтэй технологийг хөгжүүлэх, нэвтрүүлэхийг дэмжих




Зорилт тус бүрийг хангах нэгдмэл уялдаатай дэд төслүүд хэрэгжих ба Зохицуулалтын шийдвэрийн үр нөлөөтэй байдлыг зохицуулалтад нийтлэг ашиглагддаг, сайн туршлагад үндэслэн үнэлэх зарчмаар Стратегийн хэрэгжилтийг үнэлнэ.

ХҮРЭХ ҮР ДҮН (OUTPUT): ЧАНАРТАЙ ҮЙЛЧИЛГЭЭ, ХҮЧИРХЭГ/СОНГОЛТТОЙ/ХАРИУЦЛАГАТАЙ ХЭРЭГЛЭГЧ

Өмнө дурдсанчлан, стратегийн зорилгуудаа хэрэгжүүлэхийн тулд гол нөөцүүдээ зөв удирдаж, стратеги зорилгуудыг хангах нөхцөл бүрдүүлэхийн тулд тэнцвэржүүлсэн үнэлгээний жишгээр буюу Дотоод процесс, Санхүүгийн удирдлага, Байгууллагын чадамжийн талбаруудад стратегийн зорилгууд, гол хэрэгжүүлэх төслүүдийг тодорхойллоо. Үүнд:

ДОТООД ПРОЦЕСС			
СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 4: ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ИЛ ТОД, ШУУРХАЙ, ҮР АШИГТАЙ БАЙДЛЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ДОТООД ПРОЦЕССЫГ САЙЖРУУЛАХ			
П1. Зохицуулалтын үр нөлөө, үр ашигтай байдалд үнэлгээ хийх, тайлагнах нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх	П2. Зохицуулалтын хэрэгжилт хангуулах тогтолцооны нотолгоонд суурилсан, ил тод, үр ашигтай байдлыг нэмэгдүүлэх	П3. Оролцогч талуудтай нээлттэй, давтамжтай, үр ашигтай харилцаа бий болгох	П4. Гомдол, маргаан шийдвэрлэх үйл ажиллагааг хялбаршуулах, үр ашигтай байдлыг нэмэгдүүлэх
Байгууллагын бизнес процесст шинжилгээ хийх, оновчлох, цахимжуулах			

Эдгээр нь төслийн хэлбэрээр, үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөнүүдээр хэрэгжих ба төсөл тус бүрийн гүйцэтгэлийн үзүүлэлтүүдээс гадна дараах хэмжүүр үзүүлэлтүүдээр зорилтын хэрэгжилтийн үнэлнэ.



ГОЛ ТҮЛХҮҮР ДҮН		
Зохицуулалтын үр нөлөө, үр ашигтай байдалд үнэлгээ аргачлалыг олон улсын нийтлэг жишгээр тогтоож, гол зохицуулалтуудын хувьд хэрэглэж, практик үүсгэсэн байна.		
Тусгай зөвшөөрлийн гэрээний хэрэгжилтийг дүгнэх, зохицуулалтын шийдвэрт ашиглаж хэвшинэ		
Зохицуулалтын шаардлагын хэрэгжилтийг үнэлэх, шинжилгээ хийх, зохицуулалтын шийдвэрт ашиглаж хэвшинэ.		
Байгууллагын бизнес процессуудад шинжилгээ хийх, оновчлох, цахимжуулна.		
Гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлт (KPI)	Одоогийн	Зорилт
%, Тусгай зөвшөөрөл шинээр авах хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байдал	69.79%	95%
%, Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байдал	49.00%	100%
%, Тусгай зөвшөөрлийн хүсэлтийг цахим хэлбэрээр шийдвэрлэсэн байдал	5.81%	50%
%, Хэрэглэгчийн гомдол шийдвэрлэлт	98%	100%
#, Зохицуулалтын шийдвэрийн эсрэг шийдвэрлэгдсэн маргаан	1	0

САНХҮҮ

СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 5: САНХҮҮГИЙН ЗОХИСТ ХАРЬЦААГ ХАНГАХ, ҮР АШГИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ


C1. Зохицуулалтын үйлчилгээний хөлс, хязгаарлагдмал нөөцийн ашиглалт, үйлчилгээний төлбөрийг cost-cover зарчмаар шинэчлэн тогтоох

C2. Авлага үүсэхээс сэргийлэх тогтолцоо бүрдүүлэх

C3. Зардлыг үр ашигтай байх, зохицуулалтад чиглэх

Олон улсын зохицуулах байгууллагын нийтлэг жишгээр тайлагнах

Эдгээр нь төслийн хэлбэрээр, үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөнүүдээр хэрэгжих ба төсөл тус бүрийн гүйцэтгэлийн үзүүлэлтүүдээс гадна дараах хэмжүүр үзүүлэлтүүдээр зорилтын хэрэгжилтийн үнэлнэ.




Гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлт (KPI)	Одоогийн	Зорилт
#, Cost cover зарчмаар шинэчлэн тогтоосон Зохицуулалтын үйлчилгээний хөлс		2
%, Хугацаа хэтэрсэн төлбөрийн үлдэгдэлтэй тусгай зөвшөөрөл	12.3%	5%
%, Зардлын үр ашиг	Зардлын үр ашигтай, зохицуулалтын чиглэсэн байдалд дүн шинжилгээ хийж, тайлагнаж хэвшинэ.	

БАЙГУУЛЛАГЫН ЧАДАМЖ

СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 5: БАЙГУУЛЛАГА ҮНЭ ЦЭНЭТЭЙ КАПИТАЛАА НЭМЭГДҮҮЛЭХ ЗАМААР ЧАДАМЖАА БАЙНГА ДЭЭШЛҮҮЛЖ, БҮТЭЭМЖ ДЭМЖСЭН СУРАЛЦАГЧ БАЙГУУЛЛАГА БОЛОХ

<p>Ч1. Байгууллагын хараат бус статусыг бэхжүүлэх</p>	<p>Ч2. Зохицуулалтын шийдвэрт ашиглах судалгаа, өгөгдлийн чадавхийг сайжруулах, өгөгдөл/мэдээлэл тандан судалгааны тогтолцоо бүрдүүлэх</p>	<p>Ч3. Байгууллагын соёл, ажилтнуудын сэтгэл ханамжийг дээшлүүлэхэд хүний нөөцийн удирдлагыг чиглүүлж, хараат бус өндөр бүтээмжтэй Зохицуулагч бий болгох тогтолцоо бүрдүүлнэ.</p>	<p>Ч4. Байгууллагын дотоод хяналтын тогтолцоо (Дотоод аудит, босоо хяналт, процессын хяналт)-ын үр нөлөөтэй байдлыг нэмэгдүүлэх, төлөвшүүлэх</p>
--	---	---	---

Эдгээр нь төсөл/санаачлага, үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөнүүдээр хэрэгжих ба төсөл тус бүрийн гүйцэтгэлийн үзүүлэлтүүдээс гадна дараах хэмжүүр үзүүлэлтүүдээр зорилтын хэрэгжилтийн үнэлнэ.



ХҮРЭХ ГОЛ ТҮЛХҮҮР ДҮН

Бие даасан зохицуулах байгууллагын хуулийн этгээдийн статусыг оновчтой тодорхойлж, холбогдох хууль тогтоомжоор баталгаажуулна.		
Байгууллагын бүтэц, процессын зохион байгуулалтыг Зохицуулагч нарын сайн туршлагад үндэслэн оновчтой шинэчлэн зохион байгуулна.		
Нэн шаардлагатай ур чадваруудад төвлөрсөн хүний нөөцийг чадавхижуулах хөтөлбөр хэрэгжүүлсний үр дүнд хүний нөөцийн ур чадварыг нэмэгдүүлнэ.		
Үр дүн, бүтээмжид суурилсан гүйцэтгэлийн удирдлагын систем нэвтрүүлнэ.		
Байгууллагын мэдээллийн капитал чадавхижуулах хөтөлбөр хэрэгжүүлэх ба уг ажлын хүрээнд бүрдүүлсэн өгөгдлийн сангийн тоо, тэдгээрийг удирдлагын болон зохицуулалтын шийдвэрт ашиглаж байгаад үнэлгээ, шинжилгээ хийнэ.		
Гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлт (KPI)	Одоогийн	Зорилт
#, Ажилтны сэтгэл ханамжийн индекс	Хүний нөөцийн удирдлагын орчин үеийн чиг хандлагад нийцүүлэн мэргэжлийн байгууллагаар тооцоо хийлгэж, шийдвэр гаргахад ашиглана.	
#, Ажилтнуудын ур чадвар (Индекс)		
%, Бизнес төлөвлөгөөний дундаж гүйцэтгэл	89%	95%

3. НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН ГОЛ АСУУДЛУУД

3.1 ЗОХИЦУУЛАЛТЫН ШИЙДВЭР ГАРГАХ, болон бусад ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Тус хороо нь Харилцаа холбооны тухай хуулиар тусгайлан байгуулагдсан (statutory body), Харилцаа холбооны салбарын бие даасан зохицуулах байгууллага бөгөөд хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд төрийн байгууллага, үйлчилгээ эрхлэгч болон аливаа оролцогч талуудаас хараат бус үйл ажиллагаа явуулдаг.

Харилцаа холбооны зохицуулах хороо нь дарга болон орон тооны бус 6 гишүүдээс бүрдэх ба хорооны дарга, гишүүдийг Ерөнхий сайд томилно. Зохицуулах хороо нь зохицуулалтын шийдвэрийг хорооны хуралдаан⁴¹аар шийдвэрлэх ба зохицуулалтын шаардлага тогтоосон хорооны тогтоол нь захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн санд бүртгэгдсэнээр нийтээр мөрдөх эрхтэй болно.

Байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг Зохицуулах хорооны дүрэм⁴²ээр тогтоох бөгөөд одоогийн бүтэц болон бизнес процесс нь зорилтдоо хүрэхэд дэмжлэг болж байгаа эсэхэд шинжилгээ хийх, шинжилгээнд үндэслэн шаардлагатай сайжруулалтыг хийнэ.

3.2 ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГА, НЭН ШААРДЛАГАТАЙ ЧАДВАРУУД

Хүний нөөцийн удирдлагыг байгууллагын соёл, ажилтны сэтгэл ханамжийг дээшлүүлэхэд чиглүүлэн хөгжүүлж, байгууллагын бүтээмж, өдөр тутмын үйл ажиллагааны стратегид чиглэсэн, үр ашигтай байдлыг нэмэгдүүлнэ.

НЭН ШААРДЛАГАТАЙ УР ЧАДВАРУУД

Стратеги зорилгуудыг хэрэгжүүлэх, үр ашигтай зохицуулалт хийхэд зайлшгүй шаардлагатай ур чадварыг дараах байдлаар тодорхойлсон бөгөөд эдгээр чадваруудыг ажилтнуудад суулгах нөхцөлийг бүрдүүлж, хөрөнгө оруулж ажиллана. Үүнд:

ЗОХИЦУУЛАГЧИЙН УР ЧАДВАР

Хууль эрхзүйн тогтолцоо, бодлого, зохицуулалтын хүрээ, арга хэрэгслүүдийг ойлгох, зохицуулалтын арга хэрэгслүүдийг ашиглах, зохицуулалтын шилдэг туршлагыг нэвтрүүлэхтэй холбоотой цогц ур чадварыг ойлгох бөгөөд бид энэхүү стратегийн хүрээнд зохицуулалтын чадавхиа бэхжүүлж, улмаар шинээр гарч ирж буй технологи, бизнесийн загвар, хэрэглэгчийн зан төлөв, хүлээлттэй уялдуулан баримтад суурилсан зохицуулалтын тогтолцоог бий болгоход хүний нөөцийг хэрхэн чадавхижуулах байгууллагын хэрэгцээгээ тодорхойлох, түүнд тулгуурласан хүний нөөц, сургалтыг чанаржуулахад сайн зохицуулах байгууллагуудын туршлагыг бэнчмарк хийж, манлайлал үзүүлж ажиллана.

ДАТА ЛИТЕРАСИ, ШИНЖИЛГЭЭНИЙ СИСТЕМ

⁴¹ Хорооны хуралдааны дэгийг хорооны тогтоолоор баталгаажуулна.

⁴² Засгийн газрын тогтоол

Бид алсын хараагаа “Дижитал шилжилт⁴³ийг дэмжих баримтад суурилсан, уян хатан, хамтын зохицуулалттай 5 дахь үеийн⁴⁴ зохицуулах байгууллага болно” гэж томъёолсон. Энэ нь тус хороо зохицуулалтын аливаа шийдвэрийг баримтад үндэслэж гаргах тогтолцоог хөгжүүлэх, үүний тулд байгууллага дата чадавхиа сайжруулах хэрэгцээ гарч байна. Байгууллагын дата чадавхи гэдэг нь мэдээллийн олдцтой байдал, хэрэглэхүйц байдал, түүний аюулгүй байдлыг сайжруулах, ажилтнуудад өгөгдөлтэй харьцах, шийдвэрт сайн өгөгдөл ашиглах төлөвшил суулгах, ажилтнуудын аналитик чадавхийг дэмжих гэх мэт цогц ойлголт бөгөөд нэн тэргүүнд байгууллагын түвшний өгөгдлийн чадавхитай холбоотой нэгдсэн шаардлагаа тодорхойлж, дээрхи хүчин зүйлүүдийг дэмжих платформ шийдлийг бий болгох, хэрэгжүүлэх болон бусад мэдээллийн чадавхийг дэмжих төсөл, хөтөлбөрүүдэд хөрөнгө оруулна.

МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН УР, ЧАДВАР

Бид энэхүү стратегийн хугацаанд Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой харилцаа болон байгууллагын дотоод бизнес процессуудыг цахимжуулахаар зорьж байгаа бөгөөд ажилтнуудын мэдээлэл технологийн ур чадварыг хөгжүүлж, төлөвшүүлснээр хэрэглэгч төвтэй, шуурхай цахим үйлчилгээг хэрэглэгч, харилцагч нартаа хүргэж ажиллана.

ТӨСЛИЙН УДИРДЛАГА

Төслийн удирдлагын аргазүй, тухайлбал ажайл фрэймворк зэрэг ойлголтыг үйл ажиллагаандаа шингээснээр байгууллага шуурхай, үр ашигтай, бүтээлч байдлаа дэмжих нь нийтлэг болсон байна. Нөгөө талаасаа, аливаа урт, дунд хугацааны стратеги, тактик нь бизнес төлөвлөгөө болон төслүүдээр дамжиж хэрэгждэг. Энэ зорилгоор төслийн удирдлага нь удирдах ажилтнууд болон мэргэжилтнүүдийн аль алинд хөгжүүлэх ёстой гол ур чадварын нэг болох төслийн удирдлага, төсөл, хөтөлбөрийг амжилттай төлөвлөх, хэрэгжүүлэх, дуусгах ур чадварыг ажилтнуудад шингээх нь байгууллагын зорилгын нэг хэсэг юм.

БИЗНЕС АКЮМЕН

Энэ нь байгууллагын дэмжих болон нийцэл хангах процесс (хууль, эрхзүйч, дотоод аудит, санхүүгийн удирдлага гэх мэт)-т ажилладаг ажилтнуудын хувьд үндсэн бизнесээ буюу зохицуулалтын зарчим, хамрах хүрээ, зохицуулалтын арга хэрэгслүүдийн талаар цэгцтэй, нюанстай мэдлэг олгох, нөгөө талаасаа Зохицуулалт хариуцсан нэгжүүдийн ажилтан, албан хаагчдын санхүү, эдийн засаг, эрхзүйн мэдлэг, захиргаа удирдлагын талаар нэгдсэн ойлголтыг дээшлүүлснээр ажилтан албан хаагчид, үйл ажиллагааны гол асуудлуудын талаар гүнзгий ойлголттой болж, түүнийгээ үйл ажиллагаанд хэрэгжүүлэх, туршлагад үндэслэн оновчтой арга хэмжээ авах ур чадвар суух тухай, мэдлэг, ур чадварын цогц ойлголт юм.

⁴³ Дижитал шилжилт нь зөвхөн технологийн асуудал биш бөгөөд цахим технологи, сүлжээ, үйлчилгээг үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлэх тухай цогц үйл явц юм.

⁴⁴ 5 дахь үеийн зохицуулалт гэдэг нь зохицуулалтыг төр-бизнес, салбар болон салбар хооронд өргөн хүрээнд ил тод хүлээн зөвшөөрөгдөхүйц хэрэгжүүлэхийг ойлгоно.

3.3 САНХҮҮЖИЛТ, САНХҮҮГИЙН УДИРДЛАГА

Тус хороо нь тусгай зөвшөөрөл эзэмшигчид үзүүлсэн зохицуулалтын үйлчилгээний хөлс болон радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөрөөр санхүүжих ⁴⁵ бөгөөд хорооны тухайн жилийн санхүүгийн болон үйл ажиллагааны төлөвлөгөөг хорооны хуралдаанаар баталдаг⁴⁶.

Тус хороо нь санхүүгийн удирдлагаа зардлаа нөхөх (cost-cover) зарчимд чиглүүлэх бөгөөд санхүүгийн зохист харьцааг хангах, үр ашигтай байдлыг нэмэгдүүлэх зорилт тавьж ажиллана. Авлага үүсэхээс сэргийлэх тогтолцоо бүрдүүлэх, авлагыг хамгийн бага түвшинд барих, зардлыг үр ашигтай, зохицуулалтын үйл ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлэхэд чиглүүлнэ.

Санхүүгийн тайлангийн хувьд, жил бүрийн санхүүгийн тайланг аудитаар баталгаажуулж, олон нийтэд мэдээлдэг бөгөөд цаашид тайлагналыг зохицуулалтын үр нөлөөтэй байдалтай холбох талаар олон улсын сайн туршлагуудыг судалж, үйл ажиллагаандаа нэвтрүүлнэ.

3.4 ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА, ДОТООД ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

ХХЗХ-г дотоод хяналтын тогтолцоогоо сайжруулах зорилгоор 2013 оны 12 сарын 03-ны хорооны хуралдааны 06-р тэмдэглэлээр “Байгууллагын хэмжээнд дотоод аудитын үйл ажиллагааг туршилтаар нэвтрүүлэх” буюу ХХЗХ-ны даргын шууд удирдлагад нэг Дотоод аудитор ажиллахаар шийдвэрлэсэн. 2014-2015 онд Байгууллагын дотоод аудитын дүрэм, журмуудыг холбогдох хууль, ЗГ-ын нийтлэг журам/дүрэм, дотоод аудитын олон улсын стандартад нийцүүлэн бий болгох, байгууллагын үндсэн үйл ажиллагаа, тухайлсан гол процессуудын үр ашигтай болон нийцэлтэй байдалд чиглүүлэн Гүйцэтгэлийн болон Нийцлийн дотоод аудит хийж байгаад 2016 оны 9 сард хийгдсэн бүтцийн өөрчлөлтөөр байгууллагын даргын шууд удирдлагад Дотоод хяналт, аудитын алба болон зохион байгуулагдаж, санхүүгийн процессуудыг хамрахаар үйл ажиллагаа нь өргөжин ажиллаж байна. Тус хорооны “Дотоод аудитын үйл ажиллагаа хэрэгжүүлэх журам”-д Зохицуулах хорооны дотоод аудит нь эрсдэлд суурилсан байхаар заасан. Өөрөөр хэлбэл, эрсдэлтэй гэж үзсэн тухайлсан үйл ажиллагаанд дотоод аудит хийхээр дотоод аудитын жилийн төлөвлөгөө боловсруулан, хэрэгжүүлж дүгнэлт, сайжруулах зөвлөмж хүргүүлдэг.

Цаашид дотоод аудитын тогтолцоог сайжруулах, аудиторуудыг чадавхижуулах, байгууллагын үйл ажиллагаанд эрсдэлийн удирдлагын тогтолцоо нэвтрүүлэх, дотоод аудитыг эрсдэлд суурилсан зарчмыг улам бүр нэмэгдүүлэх, зөвлөмжийн хэрэгжилтийг сайжруулах шаардлагатай байна.

⁴⁵ Харилцаа холбооны тухай хуулийн 8.10

⁴⁶ Харилцаа холбооны тухай хуулийн 9.1.16

3.5 ОРОЛЦОГЧ ТАЛУУДТАЙ ХАМТЫН АЖИЛЛАГАА

Бодлогын байгууллага, хэрэглэгч, үйлчилгээ эрхлэгчид, нийлүүлэгчид болон гадаад хамтын ажиллагаагаа амжилттай удирдахгүйгээр зорилгоо амжилттай биелүүлэх боломжгүй юм.


ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА

Хорооны гадаад хамтын ажиллагаа нь Монгол улсын нэгдсэн гадаад бодлогын хүрээнд явагдах бөгөөд Захиргаа удирдлага хамтын ажиллагааны газрын чиг үүрэгт хамаарна. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын зохицуулалтын чиглэлээр Олон улсын цахилгаан холбооны байгууллага (ITU-ОУЦХБ), Ази номхон далайн цахилгаан холбооны байгууллага (АРТ-АНДЦХБ), дэлхийн болон бүс нутгийн олон улсын байгууллагатай гишүүнчлэлийн журмаар тогтсон харилцаатай бөгөөд тус тусын харилцааны үр өгөөжтэй байдлыг илүү нэмэгдүүлэхэд байнга анхаарч ажиллана.

Мөн ХХЗХ-ны гадаад хамтын ажиллагааг байгууллагын өөрийн чадамжийг дээшлүүлэхэд чиглүүлэх өргөжүүлэхэд анхаарна. Энэхүү стратегийн хүрээнд, сайн зохицуулагч (4 болон 5-р үеийн) нарын хуулийн статус, засаглал, удирдлага зохион байгуулалт (Management), өөрөөр хэлбэл, байгууллага өөрийн чадавхийг сайжруулах талын харилцааг нэмэгдүүлж ажиллана.

ДОТООД ХАМТЫН АЖИЛЛАГАА

Харилцаа холбооны зохицуулах хорооны дотоод хамтын ажиллагаа нь оролцогч талуудтай нээлттэй, давтамжтай, үр ашигтай харилцаа байх зарчмыг баримтлах бөгөөд үр дүнг үнэлж, тайлагнах тогтолцоо бий болгоход зорьж ажиллана.



Харилцаа холбооны зохицуулах хорооны дотоод хамтын ажиллагаа